

МБСХ-НЫ ШҮҮГЧДИЙН КОЛЛЕГИЙН ЖУРАМ

1. ЗОРИЛГО

МБСХ-ны шүүгчдийн коллеги нь МБСХ болон түүний гишүүд болон клубуудын зохион байгуулж байгаа тэмцээнүүдэд үйлчлэх зорилгоор байгуулагдана.

КОЛЛЕГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Коллеги багтаж байгаа шүүгчид нь дараах зэрэглэлүүдийг хангасан байх ёстой.

Үүнд:

- Олон улсын зэрэглэл – ОУБСХ-ны “А” шүүгчид
- Олон улсын зэрэглэл – ОУБСХ-ны “Б” шүүгчид
- Улсын (дээд) зэрэглэл
- Нэгдүгээр зэрэглэл
- Хоёрдугаар зэрэглэл
- Гуравдугаар зэрэглэл
- Дөрөвдүгээр зэрэглэл

Коллегийн бүрэлдэхүүнд мөн Тэргүүлэгчдээс томилсон тухайн тэмцээнд үйлчлэхээр батлагдсан ерөнхий шүүгчид орно.

Коллегийг МБСХ-ны Тэргүүлэгчдээс томилсон зохицуулагчид даргална.

2. ЗЭРЭГЛЭЛИЙН ХЭРЭГЛЭГДЭХ ХҮРЭЭ, ТЭДГЭЭРИЙГ ОЛГОХ БАЙГУУЛЛАГУУД

2.1. Дээд (Улсын) зэрэглэл

2.1.1. Дээд (улсын) зэрэглэлийн шүүгчид МБСХ болон түүний гишүүдийн зохион байгуулж байгаа бүжгийн спортын аль ч түвшний, аль ч насны ангилал, ур чадварын зэрэглэлийн тэмцээнүүдэд үйлчлэх эрхтэй.

2.1.2. Дээд (улсын) зэрэглэлийг МБСХ-ны Тэргүүлэгчдээс олгоно.

2.1.3. МБСХ-ны Тэргүүлэгчид ОУБСХ-ны Бүх дэлхийн Ерөнхий чуулганд оролцож “ОУБСХ-ны Олон улсын зэрэглэлийн шүүгч” цолыг авах шүүгчдийг зөвхөн Дээд (улсын) зэрэглэлийн шүүгчдээс тодорхойлж санал тавина.

2.2. Нэгдүгээр зэрэглэл

2.2.1. Нэгдүгээр зэрэглэлийн шүүгчид МБСХ Монгол улсын аварга шалгаруулах насанд хүрэгчдийн тэмцээн, Монгол улсын Цомын тэмцээн, Олон улсын насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээнүүдээс бусад S,A,B,C,D,E зэрэглэлийн болон түүнтэй дүйцэх спортын зэрэглэлийн тамирчид оролцсон бүжгийн спортын аливаа тэмцээнүүдэд үйлчлэх эрхтэй.

2.2.2. Нэгдүгээр зэрэглэлийг МБСХ-ны Тэргүүлэгчдээс олгоно.

2.3. Хоёрдугаар зэрэглэл

2.3.1. Хоёрдугаар зэрэглэлийн шүүгчид МБСХ Монгол улсын аварга шалгаруулах насанд хүрэгчид ба залуучуудын тэмцээн, Монгол улсын Насанд хүрэгчид, залуучуудын Цомын тэмцээн, Олон улсын насанд хүрэгчид, залуучуудын аварга шалгаруулах тэмцээнүүдээс бусад A,B,C,D,E зэрэглэлийн болон түүнтэй дүйцэх спортын зэрэглэлийн тамирчид оролцсон бүжгийн спортын аливаа тэмцээнүүдэд үйлчлэх эрхтэй.

2.3.2. Хоёрдугаар зэрэглэлийн шүүгчдийг МБСХ-ны Тэргүүлэгчдээс олгоно.

2.4. Гуравдугаар зэрэглэл

2.4.1. Гуравдугаар зэрэглэлийн шүүгчид МБСХ Монгол улсын аварга шалгаруулах насанд хүрэгчид, залуучууд, өсвөр насны тэмцээн, Насанд хүрэгчид, залуучууд, өсвөр насны Монгол улсын Цомын тэмцээн, Бүсийн (Төвийн, Баруун, Зүүн, Говийн бүсийн) аварга шалгаруулах тэмцээн, Бүсийн Цомын тэмцээн, Олон улсын насанд хүрэгчид, залуучууд, өсвөр насны тэмцээнүүдээс бусад B,C,D,E зэрэглэлийн болон түүнтэй дүйцэх спортын зэрэглэлийн тамирчид оролцсон бүжгийн спортын аливаа тэмцээнүүдэд үйлчлэх эрхтэй.

2.4.2. Гуравдугаар зэрэглэлийг МБСХ-ны орон нутгийн гишүүн байгууллагуудын Тэргүүлэгчдээс олгоно.

2.5. Дөрөвдүгээр зэрэглэл

2.5.1. Дөрөвдүгээр зэрэглэлийн шүүгчид МБСХ Монгол улсын аварга шалгаруулах тэмцээн, Монгол улсын Цомын тэмцээн, Бүсийн (Төвийн, Баруун, Зүүн, Говийн бүсийн) аварга шалгаруулах тэмцээн, Бүсийн Цомын тэмцээн, Олон улсын тэмцээнүүдээс бусад С,D,E зэрэглэлийн болон түүнтэй дүйцэх спортын зэрэглэлийн тамирчид оролцсон бүжгийн спортын аливаа тэмцээнүүдэд үйлчлэх эрхтэй.

2.5.2. Дөрөвдүгээр зэрэглэлийг МБСХ-ны орон нутгийн гишүүн байгууллагын Тэргүүлэгчдээс олгоно.

3. ЗЭРЭГЛЭЛ ОЛГОХ ШАЛГУУРУУД

3.1 Дөрөвдүгээр зэрэглэлийг олгох шалгуурууд

Дөрөвдүгээр зэрэглэлийг 21 нас хүрсэн дараах шаардлагуудыг цогцод нь хангасан бүжгийн спортын клубын багшид олгоно:

а) Бүжгийн спортын тэмцээнүүдэд тамирчны хэмжээнд оролцож байсан, аль нэг клубын дасгалжуулагчаар хоёроос доошгүй жил ажилласан,

б) С зэрэглэлийн бүжгийн хос бэлтгэсэн (МБСХ-ны орон нутгийн гишүүн байгууллагын аварга шалгаруулах тэмцээнээс доошгүй тэмцээний протоколыг үндэслэнэ) тэднийг E зэрэглэлээс нь эхлэн тогтвортой бэлтгэж байгаа,

в) М,S (МБСХ-ны аварга шалгаруулах тэмцээний протоколыг үндэслэнэ) болон А,B (МБСХ-ны Бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс багагүй тэмцээний протоколыг үндэслэнэ) тамирчны ур чадварын зэрэглэлтэй,

д) Дөрөвдүгээр зэрэглэлийн шүүгчийн цол авах МБСХ-ны аттестатчиллыг давсан,

е) МБСХ-ны Тэргүүлэгчдэд тухайн зэрэглэлийг хангасан тухай мэдүүлгээ өгсөн,

3.2 Гуравдугаар зэрэглэлийг олгох шалгуурууд

Гуравдугаар зэрэглэлийг дараах шаардлагуудыг цогцод нь хангасан шүүгчид олгоно:

а) Бүжгийн спортын аль нэг клубын дасгалжуулагчаар гурваас доошгүй жил ажилласан,

б) В зэрэглэлийн бүжгийн хос бэлтгэсэн (МБСХ-ны Бүсийн аварга шалгаруулах тэмцээний протоколыг үндэслэнэ) тэднийг D зэрэглэлээс нь эхлэн тогтвортой бэлтгэж байгаа,

в) Энэ хүртэл дөрөвдүгээр зэрэглэлийг авсан,

д) Жилийн турш арван тэмцээнд шүүгчээр оролцсон,

е) Гуравдугаар зэрэглэлийн шүүгчийн цол авах МБСХ-ны аттестатчиллыг давсан,

ф) МБСХ-ны Тэргүүлэгчдэд тухайн зэрэглэлийг хангасан тухай мэдүүлгээ өгсөн,

3.3 Хоёрдугаар зэрэглэлийг олгох шалгуурууд

Хоёрдугаар зэрэглэлийг дараах шаардлагуудыг цогцод нь хангасан шүүгчид олгоно:

а) Бүжгийн спортын аль нэг клубын дасгалжуулагчаар дөрвөөс доошгүй жил ажилласан,

б) А зэрэглэлийн бүжгийн хос бэлтгэсэн (МБСХ-ны Бүсийн аварга шалгаруулах тэмцээний протоколыг үндэслэнэ) тэднийг С зэрэглэлээс нь эхлэн тогтвортой бэлтгэж байгаа,

в) Энэ хүртэл гуравдугаар зэрэглэлээр хоёроос доошгүй жил ажилласан,

д) Жилийн турш арван тэмцээнд шүүгчээр оролцсон,

е) Хоёрдугаар зэрэглэлийн шүүгчийн цол авах МБСХ-ны аттестатчиллыг давсан,

ф) МБСХ-ны Тэргүүлэгчдэд тухайн зэрэглэлийг хангасан тухай мэдүүлгээ өгсөн

3.4 Нэгдүгээр зэрэглэлийг олгох шалгуурууд

Нэгдүгээр зэрэглэлийг дараах шаардлагуудыг цогцод нь хангасан шүүгчид олгоно:

а) Бүжгийн спортын аль нэг клубын дасгалжуулагчаар таваас доошгүй жил ажилласан,

б) МБСХ Монгол улсын аварга шалгаруулах насанд хүрэгчдийн (Латин ба Стандарт тусдаа болсон) тэмцээнд эхний гурван байр эзэлсэн эсвэл арван бүжгийн тэмцээнд эхний гурван байр эзэлсэн S зэрэглэлийн аль ч хүйсний хоёроос доошгүй тамирчин бэлтгэсэн, тэднийг В зэрэглэлээс нь эхлэн тогтвортой бэлтгэж байгаа, “МБСХ-ны насны ангилал ба ур чадварын зэрэглэлийн дүрэм”-ийн дагуу А зэрэглэлээс S зэрэглэлд дэвшихэд шаардлагатай оноог цуглуулсан

с) Энэ хүртэл хоёрдугаар зэрэглэлээр хоёроос доошгүй жил ажилласан,

д) Сүүлийн хоёр жилийн турш хориос цөөнгүй тэмцээнд шүүгчээр оролцсон,

е) МБСХ-ноос зохион байгуулсан шүүгч нарын мэргэжил дээшлүүлэх семинаруудад шаардлагатай тоогоор оролцсон,

ф) Тухайн зэрэглэлийг авах МБСХ-ны аттестатчиллыг давсан,

г) МБСХ-ны орон нутгийн гишүүн байгууллагаас тухайн зэрэглэлийг хангасан тухай батламж мэдүүлгийг МБСХ-ны Тэргүүлэгчдэд өгсөн

3.5 Дээд (улсын) зэрэглэлийг олгох шалгуурууд

Дээд (улсын) зэрэглэлийг дараах шаардлагуудыг цогцод нь хангасан шүүгчид олгоно

а) Бүжгийн спортын аль нэг клубын дасгалжуулагчаар зургаагаас доошгүй жил ажилласан,

б) МБСХ Монгол улсын аварга шалгаруулах насанд хүрэгчдийн (Латин ба Стандарт тусдаа болсон) тэмцээнд эхний гурван байр эзэлсэн эсвэл арван бүжгийн тэмцээнд эхний гурван байр эзэлсэн M зэрэглэлийн аль ч хүйсний хоёроос доошгүй тамирчин бэлтгэсэн, тэднийг В зэрэглэлээс нь эхлэн тогтвортой бэлтгэж байгаа, “МБСХ-ны насны ангилал ба ур чадварын зэрэглэлийн дүрэм”-ийн дагуу А зэрэглэлээс S зэрэглэлд дэвшихэд шаардлагатай оноог цуглуулсан

с) Энэ хүртэл нэгдүгээр зэрэглэлээр хоёроос доошгүй жил ажилласан,

д) Сүүлийн хоёр жилийн турш насанд хүрэгчид ба залуучуудын дунд зохиогдсон хориос цөөнгүй тэмцээнд шүүгчээр оролцсон

е) МБСХ-ноос зохион байгуулсан шүүгч нарын мэргэжил дээшлүүлэх семинаруудад шаардлагатай тоогоор оролцсон,

ф) Тухайн зэрэглэлийг авах МБСХ-ны аттестатчиллыг давсан,

г) МБСХ-ны орон нутгийн гишүүн байгууллагаас тухайн зэрэглэлийг хангасан тухай санал, өргөдлийг МБСХ-ны Тэргүүлэгчдэд өгсөн.

3.6 Тусгай журам

Нэгдүгээр болон дээд (улсын) зэрэглэлд нэр дэвшигчийн өргөдлийг авч хэлэлцэх үед МБСХ-ны Тэргүүлэгчид онцгой тохиолдолд 3.4, 3.5-д заагдсанаас гадна нэмэлт шалгуур ба хяналтыг удирдамж болгож болно.

4. ЭЭЛЖИТ ЗЭРЭГЛЭЛИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Дөрөв, гурав, хоёрдугаар зэрэглэлд нэр дэвшигчийн өргөдлийг МБСХ-ны орон нутгийн гишүүн байгууллагуудын Тэргүүлэгчид өөрсдийн тогтоосон хугацаандаа авч хэлэлцэнэ. Дээд болон нэгдүгээр зэрэглэлд нэр дэвшигчийн өргөдлийг МБСХ-ны Тэргүүлэгчид МБСХ-ноос зохион байгуулах шүүгчдийн мэргэжил дээшлүүлэх, аттестатчилах семинаруудын цикл явагдах жилээс бусад жил бүрийн 9-р сарын 1-нээс 10-р сарын 15 хүртэл авч хэлэлцэнэ.

5. МБСХ-ЫН ШҮҮГЧДИЙН ХЭСГИЙГ БАЙГУУЛАХ ЖУРАМ БА ШАЛГУУРУУД

5.1. Монгол улсын аварга шалгаруулах тэмцээний шүүгчдийн хэсгийг МБСХ-ны Тэргүүлэгчдээс МБСХ-ны шүүгчдийн коллегийн зохицуулагчдын боловсруулсан саналыг үндэслэн, дараах журам ба зарчмыг харгалзан байгуулна:

5.1.1. Хосын аварга шалгаруулах тэмцээний шүүгчдийн хэсэг нь долоон шүүгч (онцгой тохиолдолд ес ба түүнээс олон), Формейшн буюу хамтлагийн тэмцээний шүүгчдийн хэсэг нь таван шүүгч (онцгой тохиолдолд долоон шүүгч) –ээс бүрдэнэ.

5.1.2. Шүүгчдийн хэсэгт IDSF-ийн гишүүн гадаадын холбооны хоёроос илүүгүй шүүгч байж болно.

5.1.3. Монгол улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж байгаа тухайн орон нутгийн зөвлөлийг хоёр шүүгч төлөөлж болно.

5.1.4. Хэрэв шүүгчийн дээд доод үеийн садан, эхнэр нөхрийн, ах дүүгийн холбоотой хамаатан нь тухайн тэмцээнд орж байвал тухайн шүүгчийг шүүгчдийн хэсэгт оруулахгүй.

5.1.5. Хуанлийн жилийн хугацаанд шүүгч бүр дүрэм ёсоор нэг Монгол улсын аварга шалгаруулах тэмцээнийг шүүнэ (үүнд хүүхэл насны тэмцээн хамаарахгүй).

5.1.6. Зөвхөн МБСХ-ны Тэргүүлэгчдийн тусгай шийдвэрийг үндэслэн МБСХ-ны гишүүн бус хүнийг Шүүгчдийн хэсэгт авч ажиллуулна.

5.1.7. Шүүгчид хоёр жил дараалан нэг насны ангилал, нэг зэрэглэлийн тэмцээнийг шүүх ёсгүй.

5.2. МБСХ-ны Тэргүүлэгчид өөрсдийн үзэмжээр 5.1-д заагдсан шаардлагаас хамааралгүйгээр мэргэжилтнүүдийг шүүгчдийн хэсэгт авах эрхтэй. Тухайлбал, хүүхэд нас ба өсвөр нас 1 ангилалын тэмцээнийг шүүхэд нэгдүгээр зэрэглэлийн шүүгчдийг зөвшөөрнө.

5.3. Сонирхогчдын бүжгийн спортын тэмцээн дээр шүүгчдийн хэсэг тэмцээнийг эхнээс нь финал хүртэл шүүх ёстой. Зохион байгуулагчид шүүгчдийг дур мэдэн солихыг хориглоно.

5.4. Орон нутгийн зөвлөлийн Тэргүүлэгчид өөрсдийн болон гишүүдийнхээ зохион байгуулж байгаа тэмцээнүүдэд үйлчлэх шүүгчдийн хэсгийг байгуулах өөрсдийн шалгуурыг боловсруулж болно. Гэхдээ эдгээр шалгуурууд нь энэхүү журмын 5-р зүйлд заагдсан зарчмуудад харшилж болохгүй.

6. ШҮҮГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Шүүгчдийн үүрэг:

6.1. Хосын/хамтлагийн үзүүлбэрийг шүүхдээ урьдын амжилт, хүртсэн цол хэргэм, эзэлсэн байр, рейтингийг харгалзахгүйгээр тухайн тэмцээн/тухайн оролтон дээрх бусад хосуудын/ хамтлагуудын үзүүлбэртэй харцуулан шударга, бодитой, урьдчилан тогтоолгүйгээр шүүнэ.

6.2. Тэмцээнийг эхлэх хүртэл, завсарлагаар, төгсгөлөөр дасгалжуулагчид, тамирчид, бусад шүүгчид, зохион байгуулагчид, МБСХ-ны албаны хүмүүс, үзэгчидтэй тамирчны үзүүлбэрт өгсөн өөрийн үнэлгээний талаар хэлэлцэх, тайлбар өгөхийг оролдохгүй. Завсарлагаар зөвхөн шүүгчдийн өрөөнд байна.

6.3. Хосын үзүүлбэрийн оноог дуулгах үед талбай дээр байж, үзэгчид, хосууд, бусад шүүгчидтэй ярилцахгүй, тамирчны үзүүлбэр болон бусад шүүгчдийн ажилд аливаа нэг гадаад байдал үзүүлэхгүй, биеэ даруу төлөв, түвшин авч явж, шүүгчийн байрлалыг хаяж явахгүй, спортын комиссарын зөвшөөрөлгүйгээр шүүлтээ орхихгүй.

6.4. Бүх тэмцээний турш (завсарлага, үзүүлбэрийн үед г.м) олон нийтийн ёс зүйн хэм хэмжээг зөрчихгүй.

6.5. Энэ журмын 5.1.4-д заагдсан өөрийнхөө ойрын хамаатан садны үзүүлбэрийг шүүхээс татгалзах, тэмцээний бүртгэлийн үед иймэрхүү байдал гарвал тэмцээн эхлэхээс өмнө ерөнхий шүүгчид мэдэгдэнэ.

6.6. МБСХ-ны шүүгчдийн коллогоос өөр аливаа шүүгчдийн коллегид орохгүй.

6.7. Энэхүү журам болон тэмцээнийг явуулахтай холбоотой МБСХ-ны бусад дүрэм журам, МБСХ-ны Тэргүүлэгчдийн шийдвэрийг зөрчихгүй.

6.8. Өөрийн зэрэглэлд тохирохгүй тэмцээнд шүүгчээр оролцохгүй.

6.9. Тэмцээний байранд урьдчилан очиж, шүүгчийн үнэмлэх, хувцсаа авна.

6.10. Дүрэм журам зөрчих явдал ажиглагдвал тэмцээн болон оролтуудын завсарлагаар ерөнхий шүүгчид (спорт комиссар) мэдэгдэж, зөрчил гаргагч болон зохион байгуулагчаас зөрчлөө арилгахыг шаардана.

6.11. Тэмцээний дүнгийн протокол бичнэ.

6.12. Хэрэв шүүгч 6.1-ээс 6.11-д заагдсан зүйлсээс аль нэгийг зөрчвөл МБСХ-ны Тэргүүлэгчид болон тухайн орон нутгийн байгууллагын Тэргүүлэгчдээс түүнд дараах арга хэмжээг авна:

a) Сануулга

b) Монгол улс болон гадаадад зохиогдож байгаа тэмцээнүүдэд шүүгчээр оролцох эрхийг түр хугацаагаар хасах,

c) Зэрэглэлийг түр хугацаагаар бууруулах,

d) МБСХ-ны шүүгчдийн коллегоос гаргах.

6.13. Шүүгчдийн эрх:

Шүүгчид дараах эрх эдэлнэ:

a) Зохион байгуулагч, ерөнхий шүүгч, МБСХ-ны Тэргүүлэгчдээс өөрийн нэр хүндийг хамгаалахыг шаардах,

b) Илэрсэн дүрмийн зөрчлийг арилгахын тулд ерөнхий шүүгчээс тэмцээнийг зогсоохыг шаардах,

c) Тэмцээний зохион байгуулагч, ерөнхий шүүгчийн өөртэй нь болон тамирчидтай харьцах харьцааны талаар МБСХ-ны Тэргүүлэгчдэд гомдол мэдүүлэх.

7. ЕРӨНХИЙ ШҮҮГЧИД

7.1 Ерөнхий шүүгч бол тэмцээн дээрх хамгийн дээд албаны хүн бөгөөд захиран удирдах тухайлбал, МБСХ ба IDSF-ийн дүрэм журмыг дагаж мөрдүүлэх үүрэгтэй. Монгол улсын, бүсийн, аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүд, МБСХ болон орон нутгийн байгууллагуудын чансаа ахиулах тэмцээн, Олон улсын урилгын тэмцээн, IDSF-ийн гишүүд оролцсон нээлттэй тэмцээнүүдэд (Монголиан Опен) Ерөнхий шүүгчийг заавал томилно.

7.2 МБСХ-ны Тэргүүлэгчид Монгол улсын аварга шалгаруулах тэмцээн, IDSF-ийн гишүүд оролцсон нээлттэй тэмцээн (Монголиан Опен), Олон улсын урилгын тэмцээнүүдийн Ерөнхий шүүгчдийг зөвхөн дээд зэрэглэлийн шүүгчдээс томилно. Бусад зэрэглэлийнх байж болохгүй.

IDSF Дэлхийн аварга шалгаруулах, Дэлхийн цом, Тив, Дэд тивийн аварга шалгаруулах, IDSF-ийн дэлхийн зэрэглэлийн (Волд Опен, Интернэшнл Опен, Опен) тэмцээнүүдийн Ерөнхий шүүгчийг (chairman) IDSF-ийн Спорт эрхэлсэн захирал томилно.

Орон нутгийн гишүүн байгууллагуудын аварга шалгаруулах, чансаа ахиулах тэмцээнүүдийн Ерөнхий шүүгчийг Орон нутгийн гишүүн байгууллагын Тэргүүлэгчид томилно.

Ерөнхий шүүгч нь IDSF-ийн тэмцээн явуулах дүрэм, МБСХ-ны дүрэм журам бусад баримт бичиг, МБСХ-ны Тэргүүлэгчдийн холбогдох шийдвэртэй танилцаж бүрэн эзэмшсэн байх ёстой бөгөөд тэдгээрийн үнэн зөв хэрэглэгдэж байгаа эсэхэд хатуу хяналт тавина.

7.3 Ерөнхий шүүгчийн үүрэг:

7.3.1. Тэмцээн явагдах газарт урьдчилан очиж зохион байгуулагчийн хамт тэмцээн явуулах бүх үйлчилгээ бэлэн болсон эсэхийг шалган, шаардлагатай зүйлсийг засуулна.

7.3.2. Зохион байгуулагчийн хамт талбайг үзэж түүний хэмжээ, шалны бүрхүүл, тамирчдад аюулгүй эсэхийг шалгана.

7.3.3. Зохион байгуулагчийн хамт бүртгэлийн хэсгийн ажлын бэлэн байдал, бүртгэлийн хуудсыг зөв бөглөсөн эсэх ба түүн дээр овог нэр, төрсөн он сар өдөр, хот аймаг, МБСХ-ны гишүүн байгууллага, клубын нэр, дасгалжуулагчийн овог нэр зэрэг шаардлагатай зүйлс бичигдсэн эсэхийг шалгана.

7.3.4. Зохион байгуулагчийн хамт тооллогын комисс ба/буюу компьютерийн хэсгийн бэлэн байдал, компьютерийн гарах баримт, шүүгчдийн хуудас, финалын онооны самбарын бэлэн байдал (бүх тэмцээнд хаалттай шүүлтийг хориглоно), гаралтын бүрэлдэхүүн (гаралт бүрд 10-12-оос илүүгүй хосууд байна), урьдчилсан давааны гаралтын тоо, финалаас бусад даваа бүрийн гаралт бүр дэх хосуудын эргэлтийн тоо, тооллогын комисс ба компьютерийн хэсгийн үзэгчид дасгалжуулагчид, бусад орчноос тусгаарлагдсан эсэхтэй танилцана.

7.3.5. Зохион байгуулагчаас тэмцээний хөтөлбөрийг авч тэмцээн ба завсарлагын цагийн зохицуулалтыг үзэж судална.

7.3.6. Зохион байгуулагчийн хамт талбайн гэрэлтүүлгийг үзэж шүүгчдийн хэвийн ажиллах, тамирчдын бүжиглэхэд тохирох эсэхийг шалгана.

7.3.7. Зохион байгуулагчийн хамт тамирчдын хувцас солих өрөө тохилог эсэхийг үзэж шалгана.

7.3.8. Зохион байгуулагчийн хамт шүүгчдийн өрөөг үзэж МБСХ-ны Тэргүүлэгчдийн согтууруулах ундаатай харьцах шийдвэрийн биелэлтийг хянана. Мөн хүндэт зочид бусад уригдсан хүмүүс тусгай өрөөнд байрласан эсэхийг хянана.

7.3.9. Бие халаалтан дээр байж зохион байгуулагчаас тэмцээн дээр тавих гэж байгаа хөгжмийн фонограммыг болмжийн хэрээр сонсгохыг шаардана. Дууны найруулагч, дууны операторын ажилтай танилцана.

7.3.10. Бүх хамтлагуудын давталт сургуулилан дээр байж зохиомжоо МБСХ-ны дүрмийн дагуу найруулсныг хянана. Хэрэв зөрчил гарвал түүнд дасгалжуулагчийг анхааруулж, тэмцээнээс өмнө засахыг шаардана. Тэмцээний дүрмийн ийм зөрчлөө давтсан давтсан тохиолдолд формейшнийг гүйцэтгэх эрхийг татгалзуулна.

7.3.11. Тэмцээн эхлэхээс өмнө бүх хосуудыг харж хувцас нь МБСХ-ны дүрэмд нийцсэн эсэхийг шалгана. Дүрэм зөрчигдвөл тамирчнаас дүрэмд нийцсэн хувцас өмсөхийг шаардана.

7.3.12. Бүх тэмцээний туршид талбайд ойр байж гаралт бүрд хөгжим эхлэхээс өмнө зарлагдсан бүх хосууд талбай дээр байгаа эсэхийг ажиглана.

7.3.13. Зохион байгуулагчийн хамт тамирчдад тусламж үзүүлэх эмнэлгийн хэсэг зааланд ирсэн ба бэлэн байгаа эсэхийг шалгана.

7.3.14. Хамтлагийн тэмцээний үед шүүгчдийн суудлыг үзэгчдийн индэр дээр зөв байрлуулсан эсэхийг хянана.

7.3.15. Завсарлагын үеэр шүүгчид зөвхөн шүүгчдийн өрөөнд байж, тийш нь эмнэлгийн тусламжаас өөр хэнийг ч оруулахгүй байх нөхцлийг хангана.

7.3.16. Завсарлагаар тооллогын комиссын “хэрээснүүдийг” зөв тоолж байгаа эсэх, финалд скейтингийн 9.10, 11-р дүрэм зөв хэрэгжиж байгаа эсэхийг хянана. Өнгөрсөн давааны хүснэгтийн төгсгөлийн хэсгийг харж, оролцогчдын оноо тэнцсэн бол дараагийн шатанд орох хосуудын тоог шийдвэрлэнэ.

7.3.17. Бүх тэмцээний явцад гаралтын бүрэлдэхүүн, өнгөрсөн давааны үнэлгээг дөхөм байрлалд цаг тухайд нь өлгөж тамирчдад мэдээлж байгаа эсэхийг хянана.

7.3.18. Давааны төгсгөлөөр шүүгчдийн протоколыг шинжилж тухайн шүүгчийн үнэлгээ олонхийн үнэлгээнээс таван оноогоор зөрж байвал түүнээс учир шалтгааныг тайлбарлуулна.

7.3.19. Зохион байгуулагчийн хамт тэмцээний үед тамирчид, дасгалжуулагчид, үзэгчид, шүүгчид ёс бус ааш гаргахгүй байхыг хангаж, нийгмийн хэв журмыг дээд зэргээр сахина.

7.3.20. Хэрэв тамирчдад мөнгөн шагнал гардуулах бол зохион байгуулагч тэмцээн эхлэхээс өмнө МБСХ-ны Тэргүүлэгчдээс бичгээр зөвшөөрөл авна.

7.3.21. Тэмцээний явцад шүүгчийн бие өвдөх, нийгмийн хэв журам зөрчих, энэхүү журмын 6-р бүлгийг зөрчих болон бусад онцгой тохиолдлоор шүүгчийг солих бол МБСХ-ны

Тэргүүлэгч гишүүнтэй зөвлөлдсөний эцэст түүнийг өөр шүүгч эсвэл өөр мэргэжилтнээр солино.

7.3.22. Тэмцээний төгсгөлд бүх баримтыг (бүртгэлийн протокол, бүх тэмцээний туршийн шүүгчдийн хуудас, шүүгчдийн протокол, бүх даваануудын үнэлгээ, дүнгийн протокол) зохион байгуулагчаас авч тав хоногийн дотор өөрийн бичгэн илгэлийн хамт МБСХ-ны Тэргүүлэгчдэд гардуулна.

7.3.23. Хүүхэд нас болон Өсвөр нас-1-ийн тэмцээний Ерөнхий шүүгчийн үүрэг:

а) Ерөнхий шүүгч тэмцээний зохион байгуулагчийн хамт тэмцээн эхлэхээс өмнө тамирчдад болмоор хөдөлгөөнүүдийн жагсаалтыг дагаж мөрдүүлэх зорилгоор мэргэжилтнийн туслах хэсгийг бүрдүүлнэ.

б) Финал. Хэрвээ хос эсвэл хосууд финалын бүжгүүдийн нэгд илүү хөдөлгөөн оруулбал, Ерөнхий шүүгч тухайн бүжиг дууссаны дараа, бүжигт өгсөн үнэлгээг шүүгчид зарлахаас өмнө шүүгчдийн анхаарлыг үүнд шууд хандуулна. Энэ тохиолдолд Ерөнхий шүүгчийн шаардлагаар шүүгчид тухайн хосыг хамгийн сүүлийн байранд оруулна.

с) Хагас финал. Хэрвээ хос/хосууд хагас финалд бүжгийг гүйцэтгэх үед илүү хөдөлгөөн оруулбал, Ерөнхий шүүгч хос/хосуудын гүйцэтгэх эрхийг хасна.

д) 1/4 финал. Хэрвээ хос/хосууд 1/4 финалд бүжгийг гүйцэтгэх үедээ илүү хөдөлгөөн хийсэн ба 1/8 финалд дохио сануулга авсан бол Ерөнхий шүүгч шүүгчдийн протокол дахь тухайн хосд энэ бүжигт өгсөн “чагт”-ыг хүчингүй болгоно.

Хэрвээ хос/хосууд 1/4 финалд бүжгийг гүйцэтгэх үедээ илүү хөдөлгөөн хийсэн ба 1/8 финалд илүү хөдөлгөөн хийгээгүй бол Ерөнхий шүүгч тухайн хосд дараагийн даваанд ийм зөрчил гаргахгүй байхыг сануулна.

е) 1/8 финал. Хэрвээ хос/хосууд 1/8 финалд бүжгийг гүйцэтгэх үедээ илүү хөдөлгөөн хийсэн ба 1/16 финалд дохио сануулга авсан бол Ерөнхий шүүгч шүүгчдийн протокол дахь энэ бүжигт тухайн хосд өгсөн “чагт”-ыг хүчингүй болгоно.

Хэрвээ тухайн хос/хосууд 1/4 финалд тийм эсвэл өөр хөдөлгөөнийг хэтрүүлэн хийвэл, Ерөнхий шүүгч түүний/тэдний гүйцэтгэх эрхийг хасна.

Хэрвээ хос/хосууд 1/8 финалд бүжгийг гүйцэтгэх үедээ илүү хөдөлгөөн хийсэн ба 1/16 финалд илүү хөдөлгөөн хийгээгүй эсвэл 1/16 финал болоогүй бол Ерөнхий шүүгч тухайн хосд дараагийн даваанд ийм зөрчил гаргахгүй байхыг сануулна.

Хэрвээ тухайн хос/хосууд 1/4 финалд тийм эсвэл өөр хөдөлгөөнийг хэтрүүлэн хийвэл, Ерөнхий шүүгч шүүгчдийн протокол дахь тухайн хосд энэ бүжигт өгсөн “чагт”-ыг хүчингүй болгоно.

ф) 1/16 финал. Хэрвээ хос/хосууд 1/16 финалд бүжгийг гүйцэтгэх үедээ илүү хөдөлгөөн хийсэн ба 1/32 финалд дохио сануулга авсан бол Ерөнхий шүүгч шүүгчдийн протокол дахь энэ бүжигт тухайн хосд өгсөн “чагт”-ыг хүчингүй болгоно.

Хэрвээ тухайн хос/хосууд 1/8 финалд тийм эсвэл өөр хөдөлгөөнийг хэтрүүлэн хийвэл, Ерөнхий шүүгч түүний/тэдний гүйцэтгэх эрхийг хасна.

Хэрвээ хос/хосууд 1/16 финалд бүжгийг гүйцэтгэх үедээ илүү хөдөлгөөн хийсэн ба 1/32 финалд илүү хөдөлгөөн хийгээгүй эсвэл 1/32 финал болоогүй бол Ерөнхий шүүгч тухайн хосд дараагийн даваанд ийм зөрчил гаргахгүй байхыг сануулна.

Хэрвээ тухайн хос/хосууд 1/8 финалд тийм эсвэл өөр хөдөлгөөнийг хэтрүүлэн хийвэл, Ерөнхий шүүгч шүүгчдийн протокол дахь тухайн хосд энэ бүжигт өгсөн “чагт”-ыг хүчингүй болгоно..

Хэрвээ тухайн хос/хосууд 1/4 финалд тийм эсвэл өөр хөдөлгөөнийг хэтрүүлэн хийвэл, Ерөнхий шүүгч түүний/тэдний гүйцэтгэх эрхийг хасна.

г) 1/32 финал. Энэ даваанд Ерөнхий шүүгч хос/хосуудад зөвхөн дараагийн даваанд хөдөлгөөнийг хэтрүүлэн хийхгүй байхыг урьдчилан сануулна.

Шаардлагатай бол энэхүү журамд нэмэлт ба өөрчлөлтийг МБСХ-ны Тэргүүлэгчдээс жилд нэгээс илүүгүйгээр оруулж болно.